



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/79

Чойбалсан

Г “Бага ангийн багшийг дэмжих” төсөл Г
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, 60.1.5, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 3 дугаар хуралдааны 03/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийн 2025 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 1.1.2, тус хуралдааны 03/04 дүгээр “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш нарын хүний нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих, боловсролын олон талт үйл ажиллагаанд хамруулж мэргэжил, ур чадварыг дээшлүүлэн ажлын үр дүнгээр нь орон сууцны урьдчилгаа, төлбөрийн дэмжлэг үзүүлэх “Бага ангийн багшийг дэмжих” төслийн удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааны төсвийн задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 560.000.000 (таван зуун жаран сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.3 дахь заалт “Бага ангийн багшийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-тай байгуулах “Орон нутгийн төсөв”-өөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Нарангэрэл), Санхүү төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа) -т тус тус даалгасугай.

4.Болзолт уралдааныг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-т даалгасугай.

2125010157

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШЁЛ

Аймгийн Засаг даргын 1025
02 дугаар сарын 11-ны өдрийн
А/79 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт



“БАГА АНГИЙН БАГШ”-ИЙГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН УДИРДАМЖ

Зорилго: Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны А/07 дугаартай тушаалаар батлагдсан “Чадварлаг багш” арга хэмжээ, бага ангийн багш нарын хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих, боловсролын олон талт үйл ажиллагаанд бага ангийн багш нарыг хамруулах, багшлахуйн ур чадвар, санал, санаачилгыг дэмжин урамшуулах, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих шилдэг арга зүй, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хэрэгжих хугацаа: 2025 оны 02 дүгээр 14-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Хамрах хүрээ: Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багш нар

Шагналын сан: Багш тус бүрт 20.0 сая төгрөг, нийт 560.0 сая төгрөг

Санхүүжилтийн эх үүсвэр: Орон нутгийн төсөв

Оролцогч багш нарт тавих нийтлэг шаардлага:

1. Мэргэжлээрээ тогтвор суурьшилтай 3-аас дээш жил ажилласан байх
2. Багш мэргэжлийн ёс зүйг чанд сахин баримталдаг байх
3. Багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг өндөрт өргөдөг байх
4. Хүүхдийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр санал, санаачилгатай ажилладаг байх
5. Нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулах эрмэлзэлтэй байх
6. Сургалтад мэдээлэл, харилцааны технологийг бүтээлчээр ашиглах чадвартай байх
7. Сургууль, хамт олон, сурагч, эцэг эх, олон нийтэд ажил, амжилтаараа танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байх
8. Шавь нар нь сурлага, урлаг, хүмүүжил, спортын амжилт бүтээл гаргасан байх
9. Хүүхдийн хүмүүжил, хөгжил, төлөвшилд эцэг эх, асран хамгаалагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх, эцэг эх, асран хамгаалагч нэг бүртэй ажилладаг туршлагатай байх
10. Боловсрол судлал, хүүхдийн сэтгэл зүй, хүүхэд хамгаалал, тэгш хамруулах боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын талаар сургалт зохион байгуулахад хамтран оролцсон туршлагатай байх

Оролцогчдыг бүртгэх: Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшаар ажиллаж буй “Нийтлэг шаардлага”-ыг хангасан багш бүр оролцох эрхтэй бөгөөд 2025 оны 02 дугаар сарын 14-20-ны хооронд бүртгэнэ.

Бүртгүүлэхдээ танилцуулга, цаашдын зорилго бүхий бичлэгийг 2-3 минутад багтаан, Youtube-д байршуулсан линкийг хуулж, бүртгүүлнэ.

Танилцуулгын бүтэц:

1. Танилцуулгын эхний хэсэгт ажил мэргэжилдээ оруулсан хувь нэмэр, хичээл сургалтын үйл ажиллагаанд оруулсан шинэлэг санаа, ахиц өөрчлөлт, ур чадвар, заах арга барил, зайн сургалт зохион байгуулалтын талаар дурдсан байна.

2. Дунд хэсэгт сурагчдын хөгжил, хүмүүжилд гарсан ахиц өөрчлөлт, анги хамт олны төлөвшил, амжилтаас оруулах
3. Дараагийн хэсэгт нийгмийн идэвх, сайн дурын үйл ажиллагааны оролцоо, багш нарт сайн туршлагаа хуваалцсан, багаар хамтран ажилласан, тэдний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд оролцсон байдал, ажлын үр дүнгээ үнэлүүлсэн урамшуулал, шагналын талаар танилцуулсан байна.
4. Төгсгөл хэсэгт цаашид хүүхэд бүрийн сурах арга барилыг дэмжих, багшлах арга зүйгээ хэрхэн хөгжүүлэх, боловсролын салбарт оруулах хувь нэмрийн талаар оруулна.

НЭГДҮГЭЭР ШАТ

Хугацаа: 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 03 дугаар сарын 07-ны хооронд

Танилцуулга, бүрдүүлсэн баримт нотолгоог үндэслэн, анхан шатны шалгаруулалтаар 60 хувиас дээш гүйцэтгэлтэй багш нар дараагийн шатанд оролцох эрхтэй болно. Шаардлагатай тохиолдолд нэр дэвшигч багш болон сургалтын байгууллагатай холбогдож нэмэлт мэдээллийг тодруулна.

Шалгуур:

1. Танилцуулгын бүтэц /3 хэсэг/
2. Контентын шаардлага хугацаа, дуу, дүрс /2-3 минут/
3. Ажил мэргэжилдээ оруулсан хувь нэмэр, хичээл сургалтын үйл ажиллагаанд оруулсан шинэлэг санаа, ахиц өөрчлөлт, ур чадвар, заах арга барил, зайн сургалтын зохион байгуулалт
4. Сурагчдын хөгжил, хүмүүжилд гарсан ахиц өөрчлөлт, анги хамт олны төлөвшил, амжилт
5. Нийгмийн идэвх, сайн дурын үйл ажиллагааны оролцоо, багш нарт сайн туршлагаа хуваалцсан, багаар хамтран ажилласан, тэдний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд оролцсон байдал, эцэг эхтэй хамтран ажилласан байдал, цаашдын зорилго гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэнэ.

ХОЁРДУГААР ШАТ

Хугацаа: 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдөр

Шүүгчдээс өгсөн ур чадварын тухайн даалгаварт 60 хувиас дээш гүйцэтгэлтэй багш нар дараагийн шатанд орох эрх үүснэ.

Шалгуур:

1. Бүтээлч сэтгэлгээний арга барил хэрэглэх, асуудал шийдвэрлэх чадвар /*Нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр, төлөвлөлтийн хэрэгжилт, үр дүн, тэгш хамран сургалтын арга зүйг оновчтой хэрэгжүүлж буй байдал*/
2. Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх /*Хүндэвтэр сэдвийг сугалан суралцахуйн зорилтын хүрээнд идэвхтэй сургалтын арга, явцын үнэлгээ, ажлын хуудас, дижитал технологи ашиглан иж бүрэн хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулна. Хийсэн бүтээлийг аймгийн мэргэжлийн хөгжлийн бүлгээр түгээн дэлгэрүүлнэ.*
3. Дижитал технологийн ололт дэвшлийг ашиглан, хосолсон сургалтын арга зүйг сургалтад нэвтрүүлэн хэрэгдүүлсэн байдал /*Цахим, интерактив хичээлийн сан, хиймэл оюун ухааныг сургалтад ашиглах, ажлын хуудсаар дамжуулан, суралцагчдын сурах арга барил, бүтээлч үйлийг дэмжсэн байдал*/
4. Сургалтын хөтөлбөрийн агуулга эзэмшилт, үр дүн /*Боловсролын газраас хөндлөнгийн үнэлгээ хийх*/

5.Хүүхдийн хувийн онцлог, ялгаа, хөгжих хэрэгцээг ойлгож мэдрэх, хүүхэд бүрийн хөгжлийн түвшний ахиц, үр дүн, хүүхдийг эрсдэлээс хамгаалах үнэлгээ хийж, хүүхдийн хөгжил, хүмүүжил төлөвшил хандлагад нөлөөлөх, чиглэлээр сургууль, СНА, баг, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран хийж хэрэгжүүлсэн сайн туршлага, нийгэмд нөлөөлөх манлайллын ур чадвар /Ангитай ажиллах хөтөлбөр, хэрэгжилт, туршлага, арга зүй/

6.Харилцааны чадвар /Ярих, бичих, товч тодорхой илтгэх, экстемт илтгэл/ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэнэ.

ГУРАВДУГААР ШАТ

Хугацаа: 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдөр

Хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшил, оролцоог хангасан төсөл, арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сараас 06 дугаар сар хүртэлх хугацаанд хүүхэд, эцэг эх, иргэдийг уриалан, хэрэгжүүлсэн байх

Шалгаруулалтын туршид цуглуулсан оноо, эцсийн шатны тусгай даалгаврын гүйцэтгэлд өгөх шүүгчдийн үнэлгээ, олон нийтийн санал асуулгын дүнгээр шилдэг 1-2 багшийг шалгаруулна.

Шалгуур:

1. Үндэсний бичиг соёлоо дээдлэх, суралцах сэтгэлзүйн болон материаллаг орчин бүрдүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулан ажилласан байх
2. Бага ангийн сурагчдыг номонд дуртай болгох, номыг дээдлэн унших дадал олгох, бага ангийн суралцагчдын уншаад ойлгох чадварыг хөгжүүлэх олон талт үйл ажиллагаа / Хөгжлийн онцлог ялгаатай суралцагчдад зориулсан ном
3. Үйл ажиллагааг эцэг эх, суралцагч, олон нийтэд хүргэсэн хүртээмж
4. Үйл ажиллагаанд гарсан үр дүн
5. Олон нийтийн санал асуулгын дүн гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэнэ.

Шүүгчдийн бүрэлдэхүүн: Боловсролын газар, МУИС-ийн Зүүн бүсийн сургууль, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд шалгуур бүрд шүүгчдийн бүрэлдэхүүн өөрчлөгдөхөөр зохион байгуулалт хийнэ.

Уралдааны үе шатуудад цуглуулсан оноо болон олон нийтийн санал асуулгаар хамгийн өндөр оноо авсан 1-2 багшийг тус бүр 20,0 сая төгрөгийн орон сууцны урьдчилгаа олгоно. Уралдаанд хамгийн өндөр оноогоор шалгарсан 1-2 багшид орон сууцны урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлнэ. Шалгарсан багш нарт урамшууллын батламж гардуулан, дэмжлэгийг зориулалтын дагуу гэрээг үндэслэн шилжүүлнэ.

Хүлээгдэж буй үр дүн:

- Мэргэжлийн тасралтгүй хөгжилд багшийн манлайлал хөгжсөн байна.
- Багшийн сайн туршлага, санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг сурталчилсан байна.
- Багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

Түгээн дэлгэрүүлэлт: Улс, аймгийн хэмжээнд Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим сайт, Боловсролын газрын dornodedu.mn цахим сайт, Боловсролын газар пэйж, тухайн сургуулийн цахим хуудсаар түгээн дэлгэрүүлж, сурталчилна.

Ерөнхий зохион байгуулагч:

Боловсролын газар
Ерөнхий боловсролын сургуулиуд

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дүгээр сарын 11-ны өдрийн
А/79 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт



“БАГА АНГИЙН БАГШ”-ИЙГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН
ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зорилт	Хамрах хүрээ	Багшийн тоо	Шагнал	Нийт
1.	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжих болзолт уралдаан зохион байгуулах	ЕБС-ийн бага ангийн багш	28	20,0 сая	560,0 сая
	НИЙТ				560,0 сая

---oOo---

**ДОРНОД АЙМГИЙН ТӨРИЙН ӨМЧИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ, БҮЛГИЙН ТОО,
БАЙРНЫ ТӨСӨЛД ХАМРАГДАХ ХУВААРЬ**

№	Байгууллагын нэр	Бага ангийн багшийн тоо	1-р ангийн бүлгийн тоо	2-р ангийн бүлгийн тоо	3-р ангийн бүлгийн тоо	4-р ангийн бүлгийн тоо	5-р ангийн бүлгийн тоо	Байрны төсөлд хамрагдах хуваарь
1	Шинэ хөгжил	28	6	6	5	6	5	2
2	1-р сургууль	26	6	5	6	5	5	2
3	8-р сургууль	28	6	6	5	5	5	2
4	Хан-Уул	27	5	6	6	5	5	2
5	5-р сургууль	26	5	5	5	6	5	2
6	12-р сургууль	20	4	4	4	4	4	2
7	Баян-Уул	18	4	3	4	4	4	1
8	Цагаан-Овоо	13	2	3	3	3	2	1
9	Матад	12	2	3	2	2	3	1
10	11-р сургууль	10	2	2	2	2	2	1
11	Баяндун	10	2	2	2	2	2	1
12	Дашбалбар	10	2	2	2	2	2	1
13	Халхгол	8	2	2	2	1	2	1
14	Хөлөнбуйр	8	1	2	2	2	2	1
15	2-р сургууль	6	2	1	1	1	2	1
16	Чойбалсан	6	1	2	1	1	1	1
17	Чулуунхороот	6	2	1	1	1	1	1
18	Баянтүмэн	5	1	1	1	1	1	1
19	Булган	5	1	1	1	1	1	1
20	Гурванзагал	5	1	1	1	1	1	1
21	Сэргэлэн	5	1	1	1	1	1	1
22	Ялалт баг	5	1	1	1	1	1	1
Дүн		287	59	60	58	57	57	28